



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/13/НА-СТА-ААТҮГ

|                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Алтай хот<br>2021 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a><br>Аудитор Н.Гэрэлмаа<br>Утас: 99782918 Цахим хаяг: <a href="mailto:Gerelmaan@audit.gov.mn">Gerelmaan@audit.gov.mn</a> |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2022.03.15 № 111

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан сум бүрд алтайн брэндийг хөгжүүлж, орон нутгийн баялаг бүтээгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн маркетингийг дэмжсэн "Мазаалай Монголдой 2D анимэйшн" төсөл арга хэмжээг зохион байгуулсан.

### Аудитын гол асуудал

Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 117 дугаар тогтоолоор "Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" улсын

0702000248

төсөвт үйлдвэрийн газрын 2022 оны орлого, зардлыг 180.0 сая төгрөгөөр буюу цэвэр ашиг, алдагдалгүй төлөвлөгөөг баталсан. Энэ тогтоолын хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 93.25 хувьтай биелүүлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

|                                                | Үзүүлэлт                                          | 2021.12.31         | 2022.12.31       |
|------------------------------------------------|---------------------------------------------------|--------------------|------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                    |                  |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 29,237.5           | 67,088.8         |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 61,862.1           | 61,123.9         |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>91,099.7</b>    | <b>128,212.6</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             |                    | -                |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 91,099.7           | 128,212.6        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>91,099.7</b>    | <b>128,212.6</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                    |                  |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 237,118.7          | 238,600.0        |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 148,551.0          | 201,487.0        |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>88,567.7</b>    | <b>37,113.0</b>  |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        |                    | 0.0              |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>88,567.7</b>    | <b>37,113.0</b>  |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                    |                  |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        |                    | 0.0              |
|                                                | Өмчид гарсан өөрчлөлт                             | 91,099.7           | 91,099.7         |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 37,113.0           | 37,113.0         |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>128,212.6</b>   | <b>128,212.6</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                    |                  |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 239,650.7          | 238,600.0        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 145,981.6          | 189,596.0        |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>93,669.1</b>    | <b>49,004.0</b>  |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>-67,668.8.5</b> | <b>-12,641.0</b> |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>0.0</b>         | <b>0.0</b>       |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>26,000.3</b>    | <b>36,363.0</b>  |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |                    | 26,000.3         |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 26,000.3           | 62,363.3         |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ</b>          |                                                   |                    |                  |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          |                    |                  |
|                                                | Урсгал зардал                                     |                    |                  |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                    |                  |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             |                    |                  |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           |                    |                  |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             |                    |                  |
|                                                | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл                         |                    |                  |

Гурав. Аудитын илрүүлэлт:

### 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн 1.1 сая төгрөгийг залруулсан алдаа гаргасан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.
- ✓ Санхүүгийн байдлын тайланд Шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн олговрыг авлагаар тусгаагүй 2.0 сая төгрөгийн алдаа гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 2.2 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 0.05 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2.1 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 2 заалт албан шаардлага, хүргүүлсэн.

### 3.1 Төлбөрийн акт

- ✓ Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.05 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." -г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

- ✓ Бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг өмнөх оны зарцуулалттай харьцуулж үзэхэд 0.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөр болох 2.0 сая төгрөгийг төсвөөс төлсөн боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ"-ыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр                             | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |     |              |     | Зөвлөмж |     |
|----------------------------------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
|                                              |            |     |                                   |     |                          |     | Залруулсан |     | Залруулаагүй |     |         |     |
|                                              | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| "Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ | 2          | 3.1 | 2                                 | 3.1 | -                        | -   | 2          | 3.1 | -            | -   | -       | -   |
| Дүн                                          | 2          | 3.1 | 2                                 | 3.1 | -                        | -   | 2          | 3.1 | -            | -   | -       | -   |

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр                             | Нийт зөрчил |     | Үүнээс        |      |                 |     |         |     |                                      |                     |                                                 |     |
|----------------------------------------------|-------------|-----|---------------|------|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                              |             |     | Төлбөрийн акт |      | Албан шаардлага |     | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                              | Тоо         | Дүн | Тоо           | Дүн  | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| "Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ | 2           | 2.0 | 1             | 0.05 | 1               | 2.0 | -       | -   | -                                    | -                   | -                                               | -   |
| Дүн                                          | 2           | 2.0 | 1             | 0.05 | 1               | 2.0 | -       | -   | -                                    | -                   | -                                               | -   |

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр          | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|----------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|                                              |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|                                              | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил     |             |     |               |     |                 |     |         |     |
| "Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ | 1           | -   | -             | -   | 1               | -   | -       | -   |
| Нийт дүн                                     | 1           | -   | -             | -   | 1               | -   | -       | -   |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл



| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Өөрчлөлтгүй             | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ААТҮГ                       | 1                        | 1                           | -                  | -               | 1                       | -              | -     | -                          |
|   | НИЙТ                        | 1                        | 1                           | -                  | -               | 1                       | -              | -     | -                          |